

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК

“ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН УДИРДАХ ГАЗАР”

БОЛОН

“МАПРОУД” ХХК

НАРЫН ХООРОНД БАЙГУУЛСАН

“БОГДХАН ТӨМӨР ЗАМ” ТӨСЛИЙН ДООД БҮТЦИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН  
САНХҮҮЖИЛТИЙН ГЭРЭЭ

ГЭРЭЭНИЙ ДУГААР *СХГ-01/02*

ГЭРЭЭНИЙ ДУГААР .....

ГЭРЭЭНИЙ ДУГААР .....

УЛААНБААТАР ХОТ  
2022 он

БАТЛАВ  
“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР  
ЗАМ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ

6375405 СБА2198

1119279488

УЛААНБААТАР ХОТ

БАТЛАВ  
БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН  
ЦЭРГИЙН УДИРДАХ ГАЗРЫН  
ДАРГА, ХУРАНДАА

Н.УДААНЖАРГАЛ  
Х.БАТСАЙХАН  
2022.10.29

“БОГДХАН ТӨМӨР ЗАМ” ТӨСЛИЙН ДООД БҮТЦИЙН  
БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН САНХҮҮЖИЛТИЙН ГЭРЭЭ

БАТЛАВ  
“МАПРОУД” ХХК –ИЙН  
ЗАХИРАЛ

УЛААНБААТАР ХОТ

ТТС65:Б.МОНХБААТАР

2022 оны 10 сарын 21-ны өдөр

№

Улаанбаатар хот

Энэхүү “Богдхан төмөр зам” төслийн доод бүтцийн барилга угсралтын ажлын санхүүжилтийн гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г

1. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 32 дугаар тогтооюор баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ыг;

2. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 71 дүгээр тогтоолыг;

3. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлийг;

4. Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Батлан хамгаалахын сайд нарын 2022 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн “Тогтоолын хэрэгжилтийг хангах тухай” мн/01, мн/03, мн/28 дугаартай хамтарсан тушаалыг;

5. “Тавантолгой төмөр зам” ХХК болон “Зэвсэгт хүчний Жанжин штаб” нарын хооронд 2022 оны 7 дугаар сарын 6-ны өдөр байгуулагдсан ТТЗ-МН22/03, МН/482 дугаартай “Богдхан төмөр зам” төслийн доод бүтэц, өртөө, зөвлөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ” (цаашид “Үндсэн гэрээ” гэх)-г;

6. “Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газар” болон туслан гүйцэтгэгч “Мапроуд” ХХК нарын хооронд 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр байгуулагдсан н/35 дугаартай ““Богдхан төмөр зам” төслийн доод бүтцийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ” (цаашид “Ажил гүйцэтгэх гэрээ” гэх)-г;

7. Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн н/666 дугаар мэдэгдэл;

8. Монгол Улсын Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1 дэх хэсгийг тус тус үндэслэн,

Нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот 14230, Сүхбаатар дүүрэг, 13 дугаар хороолол, Нарны зам-62, Юнион Бьюлдинг Б блок, 11 давхарт байрлах “Тавантолгой төмөр зам” ХХК (цаашид “Захиалагч” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Н.Удаанжаргал,

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 5 дугаар хороо, Энхтайваны өргөн чөлөө-51 хаягт байрлах “Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газар” (цаашид “Гүйцэтгэгч” гэх), түүнийг төлөөлж Инженерийн дэд бүтцийн хэлтсийн дарга, хурандаа Д.Энхцог,

Нэгээ талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11 хороо, Соёмбо хотон, 54-6 тоот хаягт байрлах “Мапроуд” ХХК (цаашид “Туслан гүйцэтгэгч”, хамтад нь “Талууд” гэх), түүнийг төлөөлж санхүү, үйл ажиллагаа хариуцсан захирал С.Ариунжаргал нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь “Богдхан төмөр зам” төслийн доод бүтцийн барилга угсралтын ажлыг санхүүжүүлэхтэй холбогдон Захиалагч, Гүйцэтгэгч, Туслан гүйцэтгэгч нарын хооронд үүсэх харилцааг зохицуулах, тэдгээрийн эрх, үүрэг болон хариуцлагыг тодорхойлоход оршино.
- 1.2. Энэхүү гэрээ нь “Тавантолгой төмөр зам” ХХК болон “Зэвсэгт хүчний Жанжин штаб” нарын хооронд 2022 оны 7 дугаар сарын 6-ны өдөр байгуулагдсан ТТЗ-МН22/03,

МН/482 дугаартай “Богдхан төмөр зам төслийн доод бүтэц, өртөө, зөвлөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ”-ний нэгдмэл, салшгүй нэг хэсэг мөн болно.

- 1.3. Энэхүү гэрээ нь гүйцэтгэгч, туслан нарын хооронд 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр байгуулагдсан н/35 дугаартай ““Богдхан төмөр зам” төслийн доод бүтцийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ”-ний нэгдмэл, салшгүй нэг хэсэг мөн болно.

### **ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА**

- 2.1. Энэхүү гэрээ нь ажил гүйцэтгэх гэрээний хугацаатай адил хугацаатай байна.
- 2.2. Ажил гүйцэтгэх гэрээний хугацаа сунгагдсан тохиолдолд, түүнтэй адил хугацаагаар гэрээг сунгагдсанд тооцно.

### **ГУРАВ. САНХҮҮЖИЛТИЙН ХЭМЖЭЭ, ОЛГОХ НӨХЦӨЛ**

- 3.1. Энэхүү гэрээний дагуу санхүүжүүлэх нийт дүн нь “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний нийт үнийн дүн буюу Хавсралт 1-д тусгасан “Санхүүжилтэд сууринсан ажлын далагавар”-ын үнийн дүнтэй тэнцүү байна.
- 3.2. Туслан гүйцэтгэгчид олгох урьдчилгаа төлбөр нь “Санхүүжилтэд сууринсан ажлын даалгавар”-ын үнийн дүнгийн 30 /гуч/ хувиас ихгүй байх бөгөөд Гүйцэтгэгч туслан гүйцэтгэгчид олгох урьдчилгаа төлбөрийн хүсэлтийг цаасан 3 хувь, цахим 1 хувь үйлдэн Инженерт хүргүүлнэ.
- 3.3. Туслан гүйцэтгэгчид олгох урьдчилгаа төлбөрөөс 2022 онд 345,220,359.60 /гурван зуун дөчин таван сая хоёр зуун хорин мянга гурван зуун тавин есөн төгрөг жаран мөнгө/ төгрөгийг шилжүүлэх бөгөөд үлдэгдлийг 2023 онд олгоно.
- 3.4. Инженер нь Туслан гүйцэтгэгчид олгох урьдчилгаа төлбөрийн хүсэлтийг хүлээн авснаас хойш 14 хоногт багтаан Урьдчилгаа төлбөрийн гэрчилгээг үйлдэн эх хувийг Захиалагчид, хуулбар хувийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.
- 3.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн гэрчилгээг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан туслан гүйцэтгэгчийн Голомт банк дахь 2815101811 тоот дансанд урьдчилгаа төлбөрийг шилжүүлнэ.
- 3.6. Гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгчид төлөх явц дундын төлбөрийн мэдэгдлийг захиалагчийн хүлээн зөвшөөрсөн маягтын дагуу гүйцэтгэгчийн зүгээс төлбөл зохино гэж үзэж байгаа үнийн дүнгээр цаасан 3 хувь, цахим 1 хувь үйлдэн, холбогдох нэмэлт мэдээлэл, нотлох баримтын хамт сар бүрийн эцэст Инженерт хүргүүлнэ.
- 3.7. Инженер нь гүйцэтгэгчийн ирүүлсэн явц дундын төлбөрийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 28 хоногт багтаан үнийн дүнг хянан баталгаажуулж, явц дундын төлбөрийн гэрчилгээг үйлдэн, эх хувийг Захиалагчид, хуулбар хувийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.
- 3.8. Инженер нь явц дундын төлбөрийн мөнгөн дүнг хянан баталгаажуулахдаа Үндсэн гэрээний 12 дугаар зүйлд заасны дагуу ажлын хэмжилтийг хийсний үндсэн дээр олговол зохих мөнгөн дүнгийн тооцооллыг хийнэ.
- 3.9. Захиалагч нь явц дундын төлбөрийн гэрчилгээг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан явц дундын төлбөрийг туслан гүйцэтгэгчийн Капитрон банк дахь 2815101811 тоот дансанд шилжүүлнэ.
- 3.10. Захиалагч нь явц дундын төлбөрийн гэрчилгээнд тусгасан үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн дүнг гүйцэтгэлийн баталгаа болгон суутгаж, баталгаат хугацааг дуусах хүртэл хугацаагаар өөрийн дансанд байршуулна. Гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэлийн гэрчилгээ гарснаас хойш 21 хоногт багтаан суллана.
- 3.11. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийг зээл гэж үзэх бөгөөд явц дундын төлбөр олгох бүрт явц дундын төлбөрийн гэрчилгээгээр баталгаажсан үнийн дүнгээс урьдчилгаа төлбөр олгосон хувиар эргэн төлөх мөнгөн дүнг тооцож, суутгана.
- 3.12. Захиалагч нь Ажил гүйцэтгэх гэрээний 14.1-д заасны дагуу туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангах, төслийн удирдлагын нэгжүүдийг байрлуулах, үйл ажиллагааг тасралтгүй явуулах зорилгоор төсвийн удирдлагын зардлын дүнгээс 50 хувь буюу 119,001,570.92 төгрөгийг

урьдчилгаа, явц дундын, эцсийн төлбөр бүрээс хувь тэнцүүлэн суутган тооцож, Гүйцэтгэгчийн доорх дансанд шилжүүлнэ.

Данс эзэмшигч: Барилга-инженерийн цэргийн удирдах газар  
 Банк: Төрийн сан  
 Дансны дугаар: 100900014444  
 Регистрийн дугаар: 8313962

- 3.13. Гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгчийн ажил дуусах огнооноос хойш 84 хоногт багтаан ажил дууссан Мэдэгдлийг холбогдох баримт бичгийн хамтаар Инженерт хүргүүлнэ. Энэхүү мэдэгдэл нь туслан гүйцэтгэгчийн ажил дуусах огноо хүртэлх хугацаанд Ажил гүйцэтгэх гэрээний дагуу гүйцэтгэсэн нийт ажлын дүн, туслан гүйцэтгэгчид төлбөл зохино гэж үзэж буй үнийн дүн зэргийг агуулсан байна.
- 3.14. Гүйцэтгэгч нь гүйцэтгэлийн гэрчилгээ олгосноос хойш 56 хоногт багтаан туслан гүйцэтгэгчийн Эцсийн төлбөрийн мэдэгдлийн төсвийг нотлох баримт, дэлгэрэнгүй мэдээллийн хамт явц дундын төлбөрийн мэдэгдэл болон тайлантай ижил загвараар, цаасан 3 хувь, цахим 1 хувь үйлдэн Инженерт хүргүүлнэ.
- 3.15. Туслан гүйцэтгэгч аливаа нэмэлт төлбөр нэхэмжлээгүй, мөн Маргаан шийдвэрлэх зөвлөлд нэхэмжлэл гаргаагүй бол, Инженер эцсийн төлбөрийн мэдэгдлийн төсвийг хүлээн авмагц, өөрийн зүгээс бодитой бөгөөд олговол зохино гэж үзсэн дүнг тооцоолон Гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгчтэй зөвшилцэж, баталгаажуулна.
- 3.16. Эцсийн төлбөрийн мэдэгдлийн төсвийг зөвшилцэн баталгаажуулмагц, Гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгчийн эцсийн төлбөрийн мэдэгдэл болон төлбөр тооцоо эцэслэсэн мэдэгдлийг цаасан 3 хувь, цахим 1 хувь үйлдэн Инженерт хүргүүлнэ.
- 3.17. Инженер эцсийн төлбөрийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 28 хоногт багтаан эцсийн төлбөрийн гэрчилгээг үйлдэн, эх хувийг Захиалагчид, хуулбар хувийг гүйцэтгэгчид хүргүүлнэ.
- 3.18. Гүйцэтгэгч эцсийн төлбөрийн гэрчилгээний хуулбарыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор уг дүнтэй холбоотой аливаа нэхэмжлэл гаргаагүй тохиолдолд, талууд тухайн мөнгөн дүнг харилцан хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.
- 3.19. Захиалагч эцсийн төлбөрийн гэрчилгээг хүлээн авснаас хойш 28 хоногт багтаан туслан гүйцэтгэгчийн дансанд эцсийн төлбөрийг шилжүүлнэ.
- 3.20. Захиалагчаас туслан гүйцэтгэгчид олгох аливаа санхүүжилт нь НӨАТ тооцсон дүн байх бөгөөд туслан гүйцэтгэгч нь санхүүжилт хүлээн авсан өдөр цахим төлбөрийн системд, Захиалагчийн нэр дээр төлбөрийн баримтыг НӨАТ-тай дүн (энэхүү гэрээний 3.12-т заасны дагуу суутган тооцсон мөнгөн дүнг хассан)-ээр үйлдэн илгээнэ. Энэхүү гэрээний 3.12-т заасны дагуу суутган шилжүүлсэн мөнгөн дүнгээр Гүйцэтгэгч нь Захиалагчийн нэр дээр төлбөрийн баримтыг цахим төлбөрийн системд үйлдэн илгээнэ. Гүйцэтгэгч нь нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгч биш тул цахим төлбөрийн системд үйлдсэн баримтын НӨАТ нь 0 (тэг) дүнтэй байна.
- 3.21. Төлбөрийн гэрчилгээ нь Инженерийн зүгээс аливаа Гүйцэтгэгчийн баримт бичиг, эсхүл ажлыг хүлээн зөвшөөрсөн, баталгаажуулсан, зөвшөөрөл өгсөн, татгалзсан тухай мэдэгдлийн илэрхийлэл болохгүй.

#### ДӨРӨВ. ТООЦОО НИЙЛЭХ

- 4.1. Талууд улирал бүрийн эхний сарын 5-ны дотор өмнөх улирлын тооцоог нийлж, тооцоо нийлсэн акт үйлдэнэ.
- 4.2. Туслан гүйцэтгэгчид шилжүүлсэн аливаа төлбөрийг Гүйцэтгэгчид олгох санхүүжилтээс хасч тооцох буюу гүйцэтгэгчид төлбөл зохих төлбөрөөс төлсөн гэж үзнэ.
- 4.3. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийг авлагын дансанд, гүйцэтгэлийн баталгааны мөнгөн дүнг өглөг дансанд, явц дундын төлбөрийн гэрчилгээний мөнгөн дүнг дуусаагүй барилга дансанд тус тус бүртгэн, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна.
- 4.4. Гүйцэтгэгч нь аливаа төлбөрийн гэрчилгээний хуулбарыг хүлээн авмагц өглөг болон авлагын дансанд холбогдох бүртгэлийг хийх бөгөөд захиалагчаас санхүүжилт олгох бүрт тохируулах бичилтийг хийж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна.

- 4.5. Туслан гүйцэтгэгч нь урьдчилгаа төлбөрийг өглөг дансанд, гүйцэтгэлийн баталгааны мөнгөн дүнг авлага дансанд, явц дундын төлбөрийн гэрчилгээний мөнгөн дүнг урьдчилж олсон орлого дансанд бүртгэн, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна.

#### ТАВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1. Захиалагч нь Үндсэн гэрээ, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд заасан ажлын гүйцэтгэлийн хариуд Инженерээс ирүүлсэн явц дундын болон эцсийн төлбөрийн гэрчилгээгээр баталгаажсан мөнгөн дүнг Гүйцэтгэгчид зохих ёсоор бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.
- 5.2. Туслан гүйцэтгэгч нь Ажил гүйцэтгэх гэрээнд заасан аливаа ажил, үйлчилгээг гүйцэтгэх үүргээ биелүүлээгүй, биелүүлж чадаагүй, эсхүл захиалагчийн шаардлагад нийцээгүй тохиолдолд, захиалагчийн шаардлагад нийцүүлэн бүрэн биелүүлж дуустал Захиалагч нь явц дундын төлбөрийн гэрчилгээний мөнгөн дүнг хойшлуулах эрхтэй. Энэ тохиолдолд Инженер явц дундын төлбөрийг хойшлуулж буй шалтгааныг тодорхой дурдсан үндэслэл бүхий Мэдэгдлийг гүйцэтгэгчид хүргүүлнэ.
- 5.3. Гүйцэтгэгчийн илгээсэн аливаа төлбөрийн мэдэгдэл болон тайлангаас үл тохирол илэрсэн бол тухайн үл тохирлыг засч запруултал Захиалагч төлбөрийг хойшлуулах эрхтэй.
- 5.4. Үндсэн гэрээнд заасан аливаа доголдол илэрсэн тохиолдолд, тухайн доголдлыг засаж сайжруултал санхүүжилтийг хойшлуулах, эсхүл олгохоос татгалзах эрхтэй.

#### ЗУРГАА. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1. Гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгчийн ирүүлсэн аливаа төлбөрийн хүсэлтийг хүлээн авч, Ажил гүйцэтгэх гэрээний дагуу хяналт тавих бөгөөд өөрийн зүгээс олговол зохих дүнг тооцоолон, явц дундын төлбөрийн мэдэгдлийг үйлдэн, Үндсэн гэрээний 14.3-т заасан шаардлагыг хангасан баримт бичгийн хамт Инженерт хүргүүлнэ.
- 6.2. Гүйцэтгэгч нь Ажил гүйцэтгэх гэрээний дагуу зохих ёсоор гүйцэтгэсэн ажлынхаа төлбөрийг Захиалагчаас шаардах эрхтэй.

#### ДОЛОО. ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 7.1. Туслан гүйцэтгэгч нь хуулийн дагуу өөрийн төлөх шаардлагатай бүхий л татвар, хураамж болон төлбөрийг төлнэ.
- 7.2. Гэрээний дагуу олгосон төлбөрийг Ажил гүйцэтгэх гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулах үүрэгтэй.
- 7.3. Туслан гүйцэтгэгч нь Ажил гүйцэтгэх гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлынхаа төлбөрийг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

#### НАЙМ. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

- 8.1. Гүйцэтгэгч нь хууль тогтоомж болон гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлагаа зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үссэн аливаа үр дагавар, бусад бүхий л хариуцлага (хөхирол, алдагдал, зардлыг оролцуулан)-ын мөнгөн төлбөрийг Үндсэн гэрээнд заасны дагуу захиалагчид нөхөн төлнэ.
- 8.2. Гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгчид шилжүүлсэн аливаа санхүүжилттэй холбоотой үүсэх хариуцлагыг захиалагчийн өмнө бүрэн хариуцна.
- 8.3. Туслан гүйцэтгэгч нь хууль тогтоомж болон гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлагаа зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үссэн аливаа үр дагавар, бусад бүхий л хариуцлага (хөхирол, алдагдал, зардлыг оролцуулан)-ын мөнгөн төлбөрийг гүйцэтгэгчид нөхөн төлнэ.
- 8.4. Захиалагч нь хууль тогтоомж болон гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлага (гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгчийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүйгээс үүсэх хөхирол, алдагдал, зардлыг оролцуулан)-ыг зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үссэн аливаа үр дагавар, бусад бүхий л хариуцлагыг Үндсэн гэрээнд заасны дагуу гүйцэтгэгчид нөхөн төлнэ.

**ЕС. МАРГААН ШИЙДВЭРЛЭЛТ**

- 9.1. Гэрээнээс үүдэлтэй буюу түүнтэй холбоотойгоор Талуудын хооронд аливаа маргаан гарвал түүнийг Үндсэн гэрээний Тусгай нөхцөлийн 21-т заасны дагуу шийдвэрлэх ба Талууд нэгдсэн шийдвэрт хүрч чадаагүй бол уг маргааныг энэ гэрээний 9.2-т заасны дагуу шийдвэрлүүлнэ.
- 9.2. Энэ гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой бүх маргааныг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.
- 9.3. Гэрээнд заагаагүй бусад асуудлыг Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ.


**АРАВ. БУСАД**

- 10.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдуулан зөвхөн албан бичгээр харилцаа.
- 10.2. Гэрээг байгуулах, гэрээ хэрэгжих явцад Талуудын хоорондын харилцаа, аливаа мэдээллийг солилцохдоо холбогдох Монгол Улсын хууль тогтоомж болон үндсэн гэрээний Тусгай нөхцөлийн 1.12 дахь заалтын хүрээнд нууцлалыг хадгалж хамгаална.
- 10.3. Талууд гэрээтэй танилцаж буйх л нөхцөлийг хүлээн зөвшөөрч, харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулсан бөгөөд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

ЭНЭХҮҮ ГЭРЭЭТЭЙ ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН  
ТАЛУУДЫН ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД:


**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

  
Б.БОЛОР-ЭРДЭНЭ


2022 оны 10 сарын 21-ны өдөр

ТӨСӨЛ, ХӨГЖЛИЙН  
ГАЗРЫН ДАРГА

  
Э.ЭРДЭНЭБАТ


2022 оны 10 сарын 21-ны өдөр

ТӨСӨЛ, СУДАЛГААНЫ  
ХЭЛТСИЙН ДАРГА

  
Т.БАТЗОРИГ

2022 оны 10 сарын 21-ны өдөр

САНХҮҮ, ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ГАЗРЫН ДАРГА


  
Т.НАЙДАН

2022 оны 10 сарын 21-ны өдөр

**ГҮЙЦЭТГЭГЧИЙН  
ТӨЛӨӨЛЖ:**


ИНЖЕНЕРИЙН  
БҮТЦИЙН ДАРГА, ХУРАНДАА

ДЭД  
ХЭЛТСИЙН  
ДАРГА, ХУРАНДАА

  
Д.ЭНХЦОГ


2022 оны 10 сарын 20-ны өдөр

САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА, ХУРАНДАА

  
Ц.БАЯРГЭРЭЛ

2022 оны 10 сарын 20-ны өдөр


ЗАХИРГААНЫ  
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ГЭРЭЭ ЭРХ ЗҮЙН  
ОФИЦЕР, ДЭСЛЭГЧ

  
Г.БАТМОНХ

2022 оны 10 сарын 20-ны өдөр

**ТУСЛАН  
ГҮЙЦЭТГЭГЧИЙН  
ТӨЛӨӨЛЖ:**

САНХҮҮ,  
АЖИЛЛАГАА  
ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

  
С.АРИУНЖАРГАЛ

2022 оны 10 сарын 20-ны өдөр

ҮЙЛ

“Богдхан төмөр зам” төслийн доод бүтцийн  
барилга угсралтын ажлын санхүүжилтийн гэрээний  
хавсралт №1

БОГДХАН ТӨМӨР ЗАМ ТӨСЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ТРАНССЫН ПК1127+60-ПК1145+20 ХЭСЭГТ ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ "МАПРОУД" ХХК-ИЙН НЭГЖ ӨРТГИЙН ТӨСӨВ							
№	Ажлын нэр	Хэмжи х нэгж	Тоо хэмжээ	Нэгж өртөг (төгрөг)	Бүгд өртөг (төгрөг)	2022 онд хийх ажлын тоо хэмжээ	Өртөг (төгрөг)
ЗАМЫН ЧИГ СЭРГЭЭХ							
1	Замын чигийг сэргээх	1 км	1.780	1,327,587.00	2,363,104.86	1.780	2,363,104.86
	<b>Хэсгийн дүн</b>				<b>2,363,104.86</b>		-
Талбайн цэвэрлэгээний ажил							
1	Бульдозероор ургамлын үе хуулах	1 м.куб	8,752.770	3,494.00	30,582,178.38	8,752.770	30,582,178.38
2	Ул хөрсийг тэгшлэж нягтуулах	1 м.куб	8,752.770	3,955.00	34,617,205.35	8,752.770	34,617,205.35
3	Овоолсон сул хар хөрсийг ачигчаар ачих	1 м.куб	8,752.770	882.00	7,719,943.14	8,752.770	7,719,943.14
	<b>Хэсгийн дүн</b>				<b>72,919,326.87</b>		
Газар шорооны ажил							
1	Зөөврөөр далан байгуулах	1 м.куб	188,435.160	16,100.00	3,033,806,076.00	32,147.500	517,574,750.00
2	Шороон орд нээх	1 м.куб	6250.000	3,287.00	20,543,750.00	6,250.000	20,543,750.00
3	Шороон орд нөхөн сэргээх /бульдозероор/	1 м.куб	12,500.000	729.00	9,112,500.00		-
4	Технологийн зам барих	1 м.куб	4,272.000	11,750.00	50,196,000.00	4,272.000	50,196,000.00
	<b>Хэсгийн дүн</b>				<b>3,113,658,326.00</b>		
ХУЧИЛТЫН АЖИЛ (ТӨМӨР ЗАМЫН ДАЛАНГИЙН СУУРИЙН ДООД ҮЕ)							
1	Хучилтын үе /төмөр замын далангийн сууриний доод үе/ байгуулах	1 м.куб	5,891.320	17,100.00	100,741,572.00		-
2	Хажуугийн шуудуу, ухмалын ёөрийн шуудууг экскаватороор байгуулах	1 м.куб	2,365.760	5,402.00	12,779,835.520		-
	<b>Хэсгийн дүн</b>				<b>113,521,407.520</b>		
ЛАБОРАТОРИЙН ТУРШИЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ							
1	Хөрсний шинжилгээ	1 удаа /1000 м.куб/	44.17	607,738.00	26,841,761.67	44.17	26,843,787.46
	<b>Хэсгийн дүн</b>				<b>26,841,761.67</b>		
ОБЪЕКТИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ							
1	Объектийг ашиглалтад оруулах	1 км	1.780	103,337.22	183,940.25		-
	<b>Хэсгийн дүн</b>				<b>183,940.25</b>		

	Нийт дүн			3,329,487,867. 17	68,971.980	690,440,719.1 90
	Удирдлагын зардал			238,003,142.0 0	49,355,056.1 2	
	Удирдлагын зардлаас сүүтган шилжүүлэх дүн			119,001,570.9 2	24,677,528.0 6	
	2022 онд олгох урьдчилгаа				345,220,359. 60	

Энэхүү гэрээний 3.12-т заасны дагуу удирдлагын зардлын 50 хувь буюу 119,001,570.92 /нэг зуун арван есөн сая нэг мянга таван зуун далан төгрөг өрөн хоёр мөнгө/ төгрөгийг сүүтгуулан, Гүйцэтгэгчид шилжүүлэхийг .....*адул энэ յобуу ооре дэлж*..... байна.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

*Б.БОЛОР-ЭРДЭНЭ*  
Б.БОЛОР-ЭРДЭНЭ

2022 оны ... сарын ...-ны өдөр

ТӨСӨЛ ХӨГЖЛИЙН  
ГАЗРЫН ДАРГА

Э.ЭРДЭНЭБАТ  
Э.ЭРДЭНЭБАТ

2022 оны ... сарын ...-ны өдөр

ТӨСӨЛ, СУДАЛГААНЫ  
ХЭЛТСИЙН ДАРГА

*Т.Батзориг* Т.БАТЗОРИГ  
2022 оны 10 сарын 21-ны өдөр

САНХҮҮ, ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ГАЗРЫН ДАРГА

*Т.Найдан* Т.НАЙДАН

2022 оны 10 сарын 21-ны өдөр

ГҮЙЦЭТГЭГЧИЙН  
ТӨЛӨӨЛЖ:

ИНЖЕНЕРИЙН ДЭД  
БҮТЦИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА, ХУРАНДАА  
Д.ЭНХЦОГ

2022 оны ... сарын ...-ны өдөр

САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА, ХУРАНДАА

*Ц.Баяргэрэл* Ц.БАЯРГЭРЭЛ  
2022 оны ... сарын ...-ны өдөр

ЗАХИРГААНЫ  
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ГЭРЭЭ ЭРХ ЗҮЙН  
ОФИЦЕР, ДЭСЛЭГЧ

*Г.Батмөнх* Г.БАТМӨНХ  
2022 оны 10 сарын 20-ны өдөр

ТУСЛАН  
ГҮЙЦЭТГЭГЧИЙН  
ТӨЛӨӨЛЖ:

САНХҮҮ, АЖИЛЛАГАА  
ХАРИУЦСАН ЗАХИРАЛ  
*С.Ариунжаргал* С.АРИУНЖАРГАЛ  
УЙЛ

2022 оны 10 сарын 20-ны өдөр